Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох

хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145,686.4 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,280.0	9,035.0	4,755.0
Авлага	80,094.0	27,746.3	(52,347.7)
Бараа материал	730,127.6	678,450.2	(51,677.4)
Үндсэн хөрөнгө	1,590,571.2	1,583,722.6	(6,848.6)
Нийт хөрөнгө	1,883,821.7	1,738,135.3	(145,686.4)
Өр төлбөр	71,380.7	9,444.4	(61,936.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,812,441.0	1,728,690.9	(83,750.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,883,821.7	1,738,135.3	(145,686.4)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, өглөгийн данс байна.

Өмнөх оны татаас санхүүжилтийн авлагын 35,380.4 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан, оны эцсийн 27,746.3 мянган төгрөгийн авлагын 17,577.8 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн, 1,400.0 мянган төгрөг нь урсгал санхүүжилтийн нэр данс зөрүү гүйлгээний авлага, 8,768.5 мянган төгрөг нь тендерийн эмийн тооцооны авлага байна.

Байгууллагын даргын шийдвэрээр 2022 оны эхний хагас жилд 15,093.3 мянган төгрөгийн бараа материал акталсан, дээд шатны байгууллагаас олгосон эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч, хуваарилсан хөдөлгөөнтэй холбоотой бараа материал буурсан үзүүлэлттэй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/29 дүгээр тушаалаар 41,676.9 мянган төгрөгийн 69 нэр төрлийн 129 тоо ширхэг үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хассан, төсвийн хөрөнгөөр 7,248.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нийт 27,580.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй ирснийг бүртгэсэн байна.

Оны эхний 71,380.7 мянган төгрөгийн эмийн болон бараа материалын өглөгийг бүрэн барагдуулж, оны эцэст 9,444.4 мянган төгрөгийн өглөгтэй гарснаас 9,164.4 мянган төгрөг нь эм ханган нийлүүлэх байгууллагуудад төлөх тендерийн эмийн өглөг, 280.0 мянган төгрөг нь цэвэрлэгээний материалын үнийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 83,750.2 мянган төгрөгөөр буурч, 1,728,690.9 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 83,750.2 мянган төгрөгөөр буурч 217,355.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,110,424.0 мянга, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5 дахь заалтын дагуу олгох тэтгэмжид 1,606,905.7 мянган төгрөг авахаар төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үйл ажиллагааны зардлыг 255,849.1 мянган төгрөгөөр хасагдсан нь цалингийн зардлыг өмнөх оны цалингийн зардлын гүйцэтгэлийг үндэслэн цалингийн зардлыг хассантай холбоотой, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.5 дахь заалтын дагуу олгох тэтгэмжийн зардлыг 25,941.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,580,964.1 мянга, нийт төсвийг 2,435,539.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг дээд шатны байгууллагаас 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр төсөвт зохицуулалт хийж, байгууллагын даргын 2022 оны 336, 554, 627 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын санхүү даатгалын хэлтэст хандсаны дагуу 2022.11.14-ний өдрийн А/552 дугаар албан бичгээр төсвийг 31,768.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,467,307.9 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70603 (Эрүүл мэндийн бодлого, удирдлага) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс олгохоор батлагдсан санхүүжилтээс 6,000.0 мянган төгрөгийг дутуу олгосноос 2,461,307.9 мянган төгрөгийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 97.8 хувь буюу 601,447.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 13,817.4 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97.3 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардал хэмнэгдсэн, 83112 хөтөлбөр төслийн дотоод урсгал арга хэмжээний зардлыг гүйлгэн зарцуулах хүсэлт явуулж, батлагдаагүйн улмаас төсөвт буцаан төвлөрүүлсэн зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ХӨТӨЛБӨР 71603 ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО, УДИРДЛАГА				
1.1	АРГА ХЭМЖЭЭ 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	867,788.00	819,239.76	48,548.24	94.4%
1.2	АРГА ХЭМЖЭЭ 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,580,964.10	1,568,490.49	12,473.61	99.2%
1.3	АРГА ХЭМЖЭЭ 83112-Хөтөлбөр төслийн дотоод урсгал	18,555.80	13,923.10	4,632.70	75.0%
	Дүн	2,467,307.90	2,401,653.35	65,654.55	97.3%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ийн Хүүхдийн сан, Эрүүл мэндийн яам, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, Халдварт өвчин судлалын төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг байгууллагуудаас 324,527.7 мянга, сумдын Эрүүл мэндийн төвүүдээс тендерийн эмийн орлогоор 272,067.4 мянган төгрөг төвлөрч, өмнөх оны авлагын 35,830.6 мянган төгрөг бүрэн барагдаж, аймгийн Засаг даргын захирамжаар 54,000.0 мянган төгрөг орж, нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 687,085.7 мянган төгрөгийн орлого оржээ.

Дээрх орлогоос тайлант хугацаанд 668,053.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 19,032.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс 17,577.8 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна. Оны эцэст төвлөрүүлсэн 17,577.8 мянган төгрөгийн орлогоос тусгай зөвшөөрлийн хураамжийн орлого 585.0 мянга, тендерийн эмийн эргэн төлөлт 11,002.8 мянга, НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилт 5,075.0 мянга, сургалтын төлбөрийн дэмжлэг 1,500.0 мянга, Халдварт өвчин судлалын төвийн үлдэгдэл санхүүжилт 668.6 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгийг устгахдаа устгалын акт үйлдэж байх, кассын болон шатахууны тайланг бүрэн, үнэн зөв гаргаж байх, аймгийн Засаг даргын шийдвэрээр олгосон хөрөнгийн зарцуулалтыг холбогдох газарт тайлагнаж, үр дүнг хэлэлцэж байх зэрэг зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.12.28-ны өдрийн 737 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг 2023.01.25-ны өдөр 68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,461,307.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 36,919.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 25,843.7 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн яамнаас 2022.10.05-ны өдөр хуулийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой чиглэлийг 2/4474 дугаар албан бичгээр ирүүлсэн, тайлант онд цалин, шимтгэлийн зардлыг 41,382.7 мянга, тогтмол зардлыг 2,982.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,030.7 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 12,473.6 мянган төгрөгөөр хэмнэснийг төсөвт төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2,953,042.8 мянган төгрөгийн 52 гүйлгээ, зарлагын 1,091,537.9 мянган төгрөгийн 69 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 222,906.9 мянган төгрөгийн 53 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин байгууллагын даргын 2022 онд гаргасан 191,484.7 мянган төгрөгийн 10 тушаал, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 360,059.3 мянган төгрөгийн 24 гэрээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг нөхөн байршуулах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, 3,744.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 4,089.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, менежментийн захидлаар 1 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,744.4	2	3,744.4	100.0
Албан шаардлага	2	4,089.8	2	4,089.8	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	5	7,834.2	5	7,834.2	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЭМГ-ын 2022.07.01-ны өдрийн 360 дугаар албан бичиг

Аудитаар тогтоосон төлбөрийн актыг орон нутагт төвлөрүүлэн барагдуулж, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газарт 39,103.5 мянган төгрөгийн 6 нэр төрлийн хугацаа хэтэрсэн эмийг оны эцэст актлахаар саналыг байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс гаргасан байна.

Аудитын явцад эмийн нөөцийн үлдэгдэлд байгаа хугацаа хэтэрсэн болон хугацаа дуусах дөхөж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг гаргуулан авахад 226,819.4 мянган төгрөгийн 10 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг дуусах хугацаа 2023 оны 3-8 сард дуусахаар байна.

Иймд Эрүүл мэндийн яамнаас орон нутагт нийлүүлж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн хугацааг анхаарч, орон нутгийн байгууллагуудаас санал авсны үндсэн дээр, эрсдэлийг урьдчилан тооцоолж нийлүүлж байх мөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бусад эрүүл мэндийн нэгжүүдтэй хугацаа дуусах гэж байгаа эмийн солилцоо хийж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитаар нийт 133,802.1 мянган төгрөгийн 9 зөрчил¹ илэрснээс 785.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 20,400.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 112,620.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга 2022.11.07-ны өдөр А/98 дугаар тушаалаар эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор тухайн байгууллагад олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдад урамшуулал олгох тушаалыг гаргахдаа өөртөө 1,000.0 мянган төгрөгийг олгох шийдвэр гаргасан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэснийг зөрчсөн тул олгосон урамшууллаас суутган тооцсон шимтгэл татварын суутгалыг хасаж, 747.8 мянган төгрөгийг төсвийн захирагчаар нөхөн төлүүлж, орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 30,152.7 мянган төгрөгийн шатахууныг орлогод авахдаа нэг бүрийн үнээр тусгаж, хэмжих нэгжийг үнээр бүртгээгүй, харилцах данснаас шилжүүлсэн дүнгээр бөөн дүнгээр нягтлан бодогч бүртгэсэн, шатахууны орлого, зарлагыг нярваар дамжуулан олгоогүй, шатахууны тайланг байгууллагын нярав бэлтгэж гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022.11.07-ны өдрийн А/98 дугаар тушаалаар 11 албан хаагчдад 9,800.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон, даргын 2022.12.12-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор тухайн байгууллагад ажилласан жилээр нь тооцож, 21 албан хаагчид 11,600.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заалтыг зөрчсөн тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022.11.25-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих горим сорил боловсруулах, шийдэл гаргах жишиг үзүүлэлт”-ийн 11.1.3 дахь заалтыг үндэслэн цаашид ажиллагсдын нийгмийн хамгааллын асуудлыг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд батлуулан, хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Засаг даргын 2022.05.06-ны өдрийн А/336 дугаар захирамжаар нэн хэрэгцээтэй мэргэжлээр сургах мэргэжлийг чиглэлийг баталж, зардалд 10,000.0 мянган төгрөгийг баталж, түүний дагуу Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргал 2022.11.10-ны өдөр А/99 дүгээр тушаал гаргахдаа Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажилладаг төрсөн дүү Н.Энхтуяагийн сургалтын төлбөрт 1,000.0 мянган төгрөгийг олгох шийдвэрийг гаргасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдөж ажиллах

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2022 онд гаргасан 191,484.7 мянган төгрөгийн 10 тушаал, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 360,059.3 мянган төгрөгийн 24 гэрээг байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг мөрдөж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлэх

3. Хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/29 дүгээр тушаалаар 41,676.9 мянган төгрөгийн 69 нэр төрлийн 129 тоо ширхэг үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хасахдаа үндсэн хөрөнгө устгах актыг үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг хэрэгжүүлэн хөрөнгийг устгасан тухай актыг үйлдэж, баримтад хавсаргах, байгууллагын даргаас тавих хяналтыг сайжруулах

4. Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын нярвын дансаар 14,705.4 мянган төгрөгийг шилжүүлж, үйл ажиллагаанд зарцуулсан байхад нярав кассын тайлангаар 10,756.2 мянган төгрөгийн тайланг гаргаж, 3,949.2 мянган төгрөгийн тайланг гаргаагүй, кассын тайланг холбогдох журмын дагуу бэлтгэж гаргаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж, анхан шатны баримтыг үндэслэн тайланг бэлтгэж байх, цаашид бэлэн мөнгөний гүйлгээ гаргахгүй байх

5. Илрүүлэлт: Япон улсын Засгийн газраас "Ковид 19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн 5,994.0 мянган төгрөгийн үнэ бүхий аюулгүй ажиллагааны хайрцгийг сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохдоо байгууллагын даргын шийдвэргүйгээр олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын даргын шийдвэргүйгээр хөрөнгө хуваарилахгүй байх, анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд олгосон хөрөнгө, бараа материалын жагсаалтыг бараа материалын тайланд хавсаргах.

6. Илрүүлэлт: Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар 2022 онд 54,000.0 мянган төгрөгийг олгосныг үйл ажиллагаандаа зарцуулсан, Засаг даргын захирамжаар олгосон хөрөнгийн зарцуулалтыг холбогдох газарт тайлагнаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар олгосон төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг холбогдох байгууллагуудад танилцуулан үр дүнг хэлэлцүүлэх, нэн шаардлагатай эмч мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэхэд хөрөнгө хуваарилж байгаа нь цаашид орон нутагт нэн шаардлагатай арга хэмжээ тул арга хэмжээг үргэлжлүүлэх талаар саналыг холбогдох газруудад тавих, гэрээнд хариуцлагын асуудлыг тодорхой зааж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан албан хаагчдад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн Засаг даргын 2022.05.06-ны өдрийн А/336 дугаар захирамжаар нэн хэрэгцээтэй мэргэжлээр сургах мэргэжлийг чиглэлийг баталж, зардалд 10,000.0 мянган төгрөгийг баталж, түүний дагуу Эрүүл мэндийн газрын дарга Н.Энхжаргал 2022.11.10-ны өдөр А/99 дүгээр тушаал гаргахдаа төрсөн дүү Н.Энхтуяагийн сургалтын төлбөрт 1,000.0 мянган төгрөгийг олгох шийдвэрийг гаргасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг зөрчсөн байна.	1	1,000.0					1	1,000.0				
Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга 2022.11.07-ны өдөр А/98 дугаар тушаалаар эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор тухайн байгууллагад олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдад урамшуулал олгох тушаалыг гаргахдаа өөртөө 1,000.0 мянган төгрөгийг олгох шийдвэр гаргасан байна.	1	785.0	1	785.0								

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/29 дүгээр тушаалаар 41,676.9 мянган төгрөгийн 69 нэр төрлийн 129 тоо ширхэг үндсэн хөрөнгийг акталж бүртгэлээс хасахдаа үндсэн хөрөнгө устгах актыг үйлдээгүй байна.	1	47,676.9					1	47,676.9				
Тайлант онд байгууллагын нярвын дансаар 14,705.4 мянган төгрөгийг шилжүүлж, үйл ажиллагаанд зарцуулсан байхад нярав кассын тайлангаар 10,756.2 мянган төгрөгийн тайланг гаргаж, 3,949.2 мянган төгрөгийн тайланг гаргаагүй, кассын тайланг холбогдох журмын дагуу бэлтгэж гаргаагүй байна.	1	3,949.2					1	3,949.2				
Баянхонгор аймгийн Засаг даргын захирамжаар 2022 онд 54,000.0 мянган төгрөгийг олгосныг үйл ажиллагаандаа зарцуулсан, Засаг даргын захирамжаар олгосон хөрөнгийн зарцуулалтыг холбогдох газарт тайлагнаж ажиллаагүй байна.	1	54,000.0					1	54,000.0				
Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 30,152.7 мянган төгрөгийн шатахууныг орлогод авахдаа нэг бүрийн үнээр тусгаж, литрээр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн, бараа материалын тайланг байгууллагын нярав бэлтгэж гаргаагүй байна.	1	-			1	0						
Япон улсын Засгийн газраас "Ковид 19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн 5,994.0 мянган төгрөгийн үнэ бүхий аюулгүй ажиллагааны хайрцгийг сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад олгохдоо байгууллагын даргын шийдвэргүйгээр олгосон байна.	1	5,994.0					1	5,994.0				
Дүн	7	113,405.1	1	785.0	1	0	5	116,620.1	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын 2022 онд гаргасан 191,484.7 мянган төгрөгийн 10 тушаал, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан 360,059.3 мянган төгрөгийн 24 гэрээг байршуулаагүй байна.	1	0	-	-	-	-	1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2022.11.07-ны өдрийн А/98 дугаар тушаалаар 11 албан хаагчдад 9,800.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон, даргын 2022.12.12-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор тухайн байгууллагад ажилласан жилээр нь тооцож, 21 албан хаагчид 11,600.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	20,400.0	-	-	1	20,400.0	-	-
Дүн	1	20,400.0	-	-	1	20,400.0	-	-
Нийт дүн	2	0	0	0	1	20,400.0	1	0

---oOo---